НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр Дугаар А/02 Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн О.Пүрэвжалын гаргасан өргөдлийн дагуу Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч Б.Цогтоогийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 033/66 дугаар бүхий дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Тэгшбаяр

(Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, хурандаа)

Гишүүд:

Н.Хишигбаатар

(Онцгой байдлын ерөнхий газрын гал түймрийн улсын хяналтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа)

Ж.Хүдэрчулуун

(Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)

Ц.Барсхүү

(Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад)

3. Хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (хурандаа Л.Тэгшбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ХУРАНДАА А.ДАШНЯМ